

2018 оны 12 сарын 27 ны өдрийн ТУЗ-ийн
02/11 тоотын Хавсралт



БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ 2019-2021

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК

1. КОМПАНИЙН ТУХАЙ

1.1. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА, ТҮҮХ

Монгол Улсын Засгийн газар мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах шинэ тогтолцоог бий болгохоор 2005 оноос Дэлхийн банктай хамтран МИДТ-ийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ нь малчин ард иргэдэд ашиг тусаа өгсөн үр өгөөжтэй ажил хэрэг болж, олны талархлыг хүлээсэн билээ.

Иймд “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн 5.5 дахь заалтын хэрэгжилтийг хангаж, МИДТ-ийг цаашид үргэлжлүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2014 онд “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-ийг батлан гаргасан. Энэхүү хуулийг үндэслэн Засгийн газрын 2014 оны 280 дугаар тогтоолоор 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК зуун хувь төрийн өмчит хувьцаат компани болж байгуулагдсан ба компани нь Монгол Улсад хөдөө аж ахуйн давхар даатгалын тогтолцоог шинээр бий болгох зорилгоор амжилттай ажиллаж МИД, эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгал, улаан буудайн даатгалыг хэрэгжүүлж малчид, тариаланчид, иргэд, ААН-үүдэд санхүүгийн механизмаар эрсдэлээ хаахад туслан ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК нь МИД-ын борлуулалтыг 2015-2018 онуудад зохион байгуулсан бөгөөд 2018 онд нийт малчин өрхийн 20% буюу 33,719 малчин өрхийг даатгалд хамруулж **3 тэрбум 462 сая** төгрөгийн хураамжийг төвлөрүүлсэн байна. Энэ нь өнгөрсөн оны борлуулалттай харьцуулбал малчин өрх 9,571 өрхөөр, даатгалын хураамж 1 тэрбум 133 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлт юм.

Компанийн нийт хөрөнгө 2017 оноос 5.33 тэрбум төгрөгөөр өсөж нийт **48.72 тэрбум** төгрөгт хүрсэн нь Монгол Улсын даатгалын салбарын 15 хувийг эзэлж байна. Компанийн нөөц сан 600 сая төгрөгөөр өсөж 20.1 тэрбум төгрөгт хүрлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд уг хөтөлбөрийн 3.1.7-д “Гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, даатгалын эрсдэлийг нэгдсэн журмаар олон улсад гаргаж, зардлыг бууруулах зорилгоор давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно” гэсэн зорилт тавьж “Үндэсний давхар даатгалын тогтолцоог бүрдүүлж, Үндэсний давхар даатгалын компани байгуулах” гэж тус тус заасныг үндэслэн Үндэсний давхар даатгалын компани байгуулах хэрэгцээ шаардлага гарсан.

Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 303 тоот тогтоолоор Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлж, оноосон нэрийг Үндэсний давхар даатгалын компани болгон өөрчилсөн.

1.2. ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, даатгалын салбарын өсөлт хөгжлийг дэмжинэ.

1.3. АЛСЫН ХАРАА

Бид Монгол Улсын даатгалын зах зээлийг олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээгээр хангаж, даатгалын салбарын эдийн засгийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг дэмжинэ.

1.4. ҮНЭТ ЗҮЙЛС

- ✓ **Мэргэшсэн өндөр чадавх** – Даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин.
- ✓ **Манлайлал** – Цаашдын зорилго зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлэх нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.
- ✓ **Хамтын зүтгэл** – Бусадтай хүндэтгэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллах, бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- ✓ **Үнэнч шударга зарчим** – Монгол Улсын хууль журмыг чандлан мөрдөж, компанийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.
- ✓ **Ил тод харилцаа холбоо** – Мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, шударга, нээлттэй харилцаа холбоо тогтооно.

1.5. ЗОРИЛТ:


- ✓ Монгол Улсын давхар даатгалын чиг хандлагыг тодорхойлох тэргүүлэгч компани байна.
- ✓ Дотоодын давхар даатгалын санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.
- ✓ Даатгалын зах зээлд тогтвортой оршин тогтнож, байгууллагын санхүүгийн тогтвортой өсөлтийг хангаж ажиллана.
- ✓ Олон улсын давхар даатгагчдын гүүр болж, олон улс дахь бизнесийн харилцаагаа өргөжүүлнэ.
- ✓ Үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн давхар даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ.
- ✓ Даатгалын чадварлаг боловсон хүчнийг бэлтгэнэ.

2. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1. КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үндэсний давхар даатгал ХК нь Андеррайтингийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Комплаенс, нөхөн төлбөрийн газар, Эрсдэлийн менежмент, хөрөнгийн удирдлагын газар, Захиргаа, удирдлагын газар гэсэн 5 газар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.

Байгууллагын бүтэц



3. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.1. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2019-2021

ҮЗҮҮЛЭЛТ		2019	2020	2021
		/мян.төг/	/мян.төг/	/мян.төг/
1	I.ОРЛОГЫН ДҮН	7,558,336	8,207,073	8,933,961
1.1	Төсвөөс урсгал санхүүжилт	-	-	-
1.2.1	Нийт даатгалын хураамж (дээд, дунд түвшин)	1,815,511	2,248,488	2,824,686
1.2.2	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,943,660	2,435,086	2,585,775
1.2.3	ҮҮА-ны Нийт орлого	3,759,171	4,683,573	5,410,461
1.3	Бондын өгөөж	-	-	-
1.4	Хөрөнгө оруулалтын орлого	3,799,165	3,523,500	3,523,500
1.5	Бусад орлого	-	-	-
2	Даатгалын зардал	2,024,137	2,333,534	2,716,065
2.1	Нийт төлсөн нэхэмжлэл /Нөхөн төлбөр/	-	-	-
2.2	Дээд болон дунд түвшний нөөц сангийн зардал	376,637	450,000	550,000
2.3	Гадаад шилжүүлэг /ОУДД-ын хураамж (retrosession)/	1,647,500	1,883,534	2,166,065
2.4	Нийт зардлын орлогод эзлэх хувь	36.59%	36.26%	35.94%
3	II.НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	2,765,621	2,975,808	3,210,897
4	A.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,765,621	2,975,808	3,210,897
4.1	Бараа үйлчилгээний зардал	1,576,708	1,696,538	1,830,564
4.2	Бараа үйлчилгээний бусад зардал	1,102,013	1,185,766	1,279,442
4.3	Татаас ба урсгал шилжүүлэг	86,900	93,504	100,891
5	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,768,578	2,897,731	3,006,999
6	Орлогын албан татварын зардал	379,916	352,350	352,350
7	Татварын дараах ашиг (алдагдал)	2,388,662	2,545,381	2,654,649